



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 06 сарын 21 өдөр

Дугаар А/53

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудал, амралтын
газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл
олгох, цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгж, иргэнд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Аглаг Эрдэнэ ХХК-ны "Аглаг Эрдэнэ" дэн буудлын 13/270, Бадман дэлгэрэх ХХК-ны "Дэлгэрэх" зочид буудлын 13/161, Цорс буянт ХХК-ны "Аэро" Дэн буудлын 16/026, Сод топаз ХХК-ны "Топаз" зочид буудлын 13/177, Авдар өргөө "Жэй" зочид буудлын 15/057, Тэнгэрийн дуу ХХК-ны "Хит хаус" зочид буудлын 15/041, Алтан долгио ХХК-ны "Гүн молор" зочид буудлын 15/013 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

4. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод хяналт тавьж ажиллахыг ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д даалгасугай.

5. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэдтэй гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-д үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг

1150500207

хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн /Б.Отгонсүвд/-д үүрэг болгосугай.

ДАРГА *D. Batmoo* Д.БАТСҮХ



Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2017 оны 06 сарын 01
өдрийн 53 дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2017.06.21

Улаанбаатар хот

| Д/д | Иргэн, аж ахуйн нэгжийн нэр | Эзэмшигчийн регистрийн дугаар | Оноосон нэр | Байршил |
|-----|-----------------------------|-------------------------------|-------------|---|
| 1 | Сод топаз ХХК | 5127041 | Топаз | БГД-ийн 5-р хороо Энхтайваны өргөн чөлөө-84 |
| 2 | Хос бэрс ХХК | 5009995 | Бэрс | БГД-ийн 20-р хороо Үйлдвэрийн баруун бүс, Эрчим хүчний 41/3 |
| 3 | Авдар өргөө ХХК | 5234476 | Жэй | СБД-ийн 1-р хороо Автозамчдын гудамж-34 |
| 4 | Тэнгэрийн дуу ХХК | 5237378 | Хит хаус | БЗД-ийн 10-р хороо Гачууртын зам-94а |
| 5 | Алтан долгио ХХК | 2672103 | Гүн молор | БЗД-ийн 1-р хороо Токиогийн гудамж-30/1 |
| 6 | Бадман дэлгэрэх ХХК | 5047242 | Дэлгэрэх | БЗД-ийн 13-р хороо Алтантэвш АОС-93 |

--ooOoo--

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2017 оны 06 сарын 21
өдрийн А/БЗ дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2017.06.21

Улаанбаатар хот

| Д/д | Иргэн, аж ахуйн нэгжийн нэр | Улсын бүртгэлийн дугаар | Оноосон нэр | Байршил |
|-----|-----------------------------|-------------------------|--------------|--|
| 1 | Аглаг Эрдэнэ ХХК | 5175429 | Аглаг Эрдэнэ | ЧД-ийн 11-р хороо Нуурын 19-404 |
| 2 | ТБА ХХК | 2708108 | Наран | БЗД-ийн 22-р хороо Өлгийн 11/152 |
| 3 | Цорс буянт ХХК | 2560852 | Аэро | ХУД-ийн 10-р хороо Морингийн зам-33 |

--ooOoo--